

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

А хувилбар

Хугацаа 80 минут

Нийт оноо 40

МОНГОЛ ТОЛБО

Залуухан сувилагч бүсгүй нүд нь орой дээрээ гарчихсан гүйж ирээд их л гэмшсэн байдалтайгаар нэг үг хэлэх гэснээ түгдрэн зогтосов.

Манай ууган охин Москвагийн нэгэн төрөх тасагт мэндлээд хэдхэн хоног болж байсан цаг л даа.

-Охин зүгээр биз! гэж сандран асуувал сувилагч бүсгүй толгой сэгсрэн

-Ууцан дээр нь алга дарам газар хөх няц болчихож, Ойчихсон байх аа! Эсвэл юманд цохьчихсон юм шиг хөх няц болсон байна. Би ердөө санахгүй байна гэж хоолойгоо чичрүүлэн хэлэв. Ууцан дээгүүрх “хөх няц” гэдэг нь ердөө л монгол хүүхэд бүрд байдаг төрөлхийн хөх толбо ажээ. Би инээдээ барьж ядан:

-Хөх няц биш! Монгол хүүхэд нялхдаа ийм байдаг юм гэсэн чинь тэр итгэж ядан охиныг дахин манцуйлж эхлэв...

...Тэр цагаас эхэлж монгол толбоны тухай би эргэцүүлэн боддог болсон юм. Монгол хүнээс өөр хэн ч тийм хөх толботой төрдөггүй учраас дэлхийн анагаах ухаанд “Монгол толбо” гэж нэрлэгдсэн энэ үзэгдэл одоо хүртэл бүрэн тайлбарлагдаагүй байна.

Монгол толботой хүмүүс дэлхийн өөр орон нутагт байдаг нь илэрхий болж бас гайхаш төрүүллээ. Мажаар хүмүүс дотор монгол толботой хүүхэд төрдөг ажээ. Тэр ч арга буюу монгол гаралтайгаа үзүүлж байгаа хэрэг юм. Хортобаажийн тал нутагт Ижил мөрнөөс нүүж очсон хүннү нарын удам угсаа учраас, арга буюу монгол толботой байгаа юм. Гэтэл алс тэртээ хойт Америкад бас “монгол толботой” хүмүүс байдаг нь ямар учир вэ?

“...намхан нуруутай, урт гартай, тавхай сарвуу богинотой боловч бусадтай харьцуулахад гавал томтой хүмүүс байжээ. Майя хүүхэд төрөхдөө “монгол толбо” гэгдсэн Дорнод Азийнханд байдаг тэмдэгтэй байх нь олонтаа. Энэ нь жижигхэн хөх толбо бөгөөд тийм гэх хэлбэргүй, ууцны төгсгөл хавьцаа байдаг тэгээд арван насанд арилдаг” гэж эртний соёл судлаач нэрт эрдэмтэн Сильванце Морли бичжээ.

“Америкийн индейчүүдийн шууд өвөг нь Байгаль орчмоор аж төрж байсан шинэ чулуун зэвсгийн үеийн хүмүүс бөгөөд шошооныхон бол индейчүүдэд бүр ойр төрөл юм” гэж нэрт эрдэмтэн Алеш Хрдлынхан бичжээ.

Нэгэн зүйл. Майя нар өөрийн бичиг, үсэгтэй, зургаан оронтой тоогоор тооцоо хийдэг, асар өвөрмөц цац суврага барьж чаддаг, алт мөнгө эдэлдэг, өндөр соёлтой хүмүүс болтлоо өсөж хөгжжээ. Азид байхдаа үүнийг чаддаг үүнийг чаддаг байгаагүй нь илэрхий. Гэхдээ чадах бэлтгэлээ хийчихсэн байж болно. Колумбын өмнөх индейчүүдийн Кечуа омгийнхон хүй нэгдлээ “айл” гэдэг байжээ. Энэ нь зүсээ огтхон ч хувилгаагүй монгол үг юм. Айл аймаг, айлсах, буух гэдэг бидний үг маань “ай” гэсэн эхээс л цөм

төрсөн юм. Үүнээс олон үг салбарлан төржээ. Индейчүүд монголчуудаас ганцхан үг хожим сураагүй нь тодорхой. Айл гэдэг бол ганц нэгээрээ амьдрахаас хэдий нь өнгөрөөд нийтээрээ, хамт олноороо аж төрөх болсон үеийн нэр. Индейчүүд тэгэхээрээ Азид байхдаа хүний зохион байгуулалттай хамтлаг болчихсон байжээ.

Айл гэдэг үгийг “аалы”, “аул”, “аил” гэх мэтээр нутгийн аялга оруулаад одоо хүртэл дунд Ази, Кавказ, Тундр хүртэлх өргөн дайдад суугчид хэрэглэсээр байна. Энэ бол биед биш сэтгэлд байгаа “монгол толбо” мөн. “Өсөхөөс сурсан үндсэн хэл мартаж болшгүй соёл”

Бас нэг зүйл. Бажий тоглодоггүй монгол хүн ховор байлаа. Бажийдаж өвлийн шөнийн уртыг бардаг байв. Эцэг дээдсээс уламжилсан энэ тоглоомоор индейчүүд бас тоглож байгаа гэж хэлбэл хэний ч санаанд ордоггүй юм. Гэтэл индейчүүд бажийдсаар өдийг хүрснээр барахгүй тэр тоглоомыг яг л монголоор нэрлэсэн хэвээр байна. Өчүүхэн ялгаа нь гэвэл бид бажий гэнэ, тэд пажингаа гэнэ. Монгол нутгаас тарсан тэр эртний тоглоомыг Балканы хойг дээрх булшнаас, индейчүүдийн оршуулган дотроос тус тус олжээ. Энэ бол биед биш ахуйд үлдсэн “монгол толбо” юм. Өсөхөөс тоглосон үндэсний тоглоом хаяж болшгүй соёл мөн.

Бас нэг зүйл. Америкийн индейчүүдийн дотор тлингид, шошоон омог байсаар байна. Гэтэл энэхүү тэлэнгүүдэд, шошоонууд нь яг тэр нэрээрээ манайд үлджээ. Тэр мөрөөр эрдэмтэн Алеш Хрдлычка энэ зууны эхээр монголд ирж, долоон хошуу даншиг наадамд цугларсан долоон мянган монгол хүний толгойн хэмжээг авч судлаад Америкийн индейчүүд Монголоос очжээ гэж лавтай хэлсэн юм. Түүний үгийг нотолж Америкад одоо хүртэл олдсон хамгийн эртний хүний гавлын яс нь индейчүүдийнх байж, монголжуу хэлбэр маягийг хадгалсан байгаа ажээ.

“Монгол толбо” ийнхүү төрөл арилживч балран арилахгүй явсаар дэлхийн хоёр бөөрөн дээр үлджээ. Л. ТҮДЭВ 1980 он

1. Эхийг дурсамж найруулал гэдгийг жишээгээр батлаарай. \ 4 оноо \

.....
.....

2. Өгүүлбэрээс холбох үгийг олж, утга, үүргийг тайлбарлана уу? / 4 оноо /

Эцэг дээдсээс уламжилсан энэ тоглоомоор индейчүүд тоглож байгаа гэж хэний ч санаанд оршгүй юм. Гэтэл индейчүүд бажийдсаар өдийг хүрснээр барахгүй тэр тоглоомыг яг л монголоор нь нэрлэсэн хэвээр байна.

.....
.....

3. Эхээс тайлбарлагдаж буй юм, тайлбарлаж буй хэсгийг ялган бичээрэй. / 4 оноо /

.....
.....

Зөв бичих дүрэм:

4. Эхээс гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гэж бичих үг 2ыг бичээрэй \2оноо\

.....

5. Дараах үгсийн зөв бичих дүрмийг тайлбарлаарай. \2оноо\
морийг
хамтлагийн

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Б хувилбар

Хугацаа 80 минут

нийт оноо 40

Алтай

Аав мориноос ойчиж, нуруугаа гэмтээн, хэвтэрт оров. Ээж аавын оронд тэмээ малд шогших болсноосоо болоод гэрийн бараа харахыг болив.

Аавд цай аягалж өгөх, дэр хучлагыг нь засах, хэтэвчийг нь дөхүүлэх ажил надад оногдсон учраас хотны баруун хойно өрсөн чулуун тоглоомон дээрээ очиж тоглож чадахгүй болсоор нэлээд хоночхов. Ээжийг малд мордмогц би гэрийнхээ хаяанд ээжийг далд ортол нь харан зогсоно. Ээжийг далд оров уу, үгүй юу “Алтай” хэмээн аав гэр дотроос дуудна. Аан хэмээн хариу өгөнгүүтээ би гэртээ гүйж орж, аавын орны дэргэд очин “Юүгээ вэ?, ааваа гэнэ . Аав эс дуугарна. Нүдээ ч үл чавчин, тооноор тэнгэр ширтэн хэвтэнэ. Би хариу хүлээн зогсож зогсож, аавыг юм хэлэхгүй болохоор нь сэмхэн гишгэлсээр буцаад гарна. Гэрийнхээ үүдэнд аавыг дуудах болов уу хэмээн чих тавин хэсэг зогсоно. Огт чимээ үл гарна. Аавыг дуудахгүй болохоор нь чулуун тоглоом уруу гүйчихмээр санагдавч гэнэт дуудах болов уу хэмээн бас бодогдож тээнэгэлзэнэ.

Явж чадахгүй байж хий дэмий гэрийнхээ хаяанд суун нүцгэн хөл дээрээ шороо нэг асгаж нэг болино. Чимээ чагнана. Аавын тухай бодогдоно. “Тэртээ баруун зүгт орших Алтай гэдэг хана хэрэм мэт их уулсын бэлд аав чинь төрсөн юм гэнэ лээ” гэж ээжийн ярьсан санаанд ургана. “Ижийгийн чинь аавыг өргөж тээх болоод энэ хээр талд ирж нутаглах болсон юм даа” гэж аавын хэлж байсан бодогдоно.

Хүүхдүүд Баяр, Жаргал, Энхээ энэ тэр гэсэн гоё гоё нэртэй байхад би яагаад ганцаархнаа ийм хачин нэртэй болчихсон юм бэ? гэхэд аав, Зүгээр, миний хүү . Энэ чинь сайхан нэр. Чамайг том болох тусам нэр чинь улам томорно гэхэд нь би “Миний нэрийг та өгсөн юм уу?” гэлээ. Тиймээ. Ээж чинь Баатар гэсэн нэр өгөх гэхээр нь би төрсөн нутгийнхаа уулыг дуудаж байя гэж бодоод чамд “Алтай” гэж нэр өгсөн юм. “Алттай” гэдэг үг сунжраад ийм үг болсон ч байж мэднэ. Манай Алтайн нуруу хэзээнээс нааш алт эрдэнэсээр баян орон юм гэнэ лээ гэсэн сэн.

Тэгэхэд нь би Баатар гэж нэртэй болсон бол Жагарын баатрууд шиг баатар эр болох байсан байх байх даа. Тэгсэн бол шөнө орой гадаа гарахдаа огт айдаггүй хүн болох байсан байх ч гэж бас бодогдоно. Аав гэнэт миний нэрийг андуураад “Баатар” гэж дуудаасай. Тэгвэл мөн ч гоёо гэж бас мөрөөднө. Тэгэж дуудахыг сонсох гэж байгаа юм шиг чагнана. Чимээ эс гарна. Дахиад л хөл дээрээ шороо асгана. Намрын шар нарны илч шингэсэн шороо хөл бүлээцүүлэх нь таатай. Чингэтэл аав гэрээс “Алтай” хэмээн дуудна. Ухасхийн босож явуут дундаа “Аан” хэмээн дуугараад гэртээ гүйн орж, аавын орны дэргэд очно. Аав юу ч эс хэлнэ. Хэсэг хүлээн зогсож байгаад дахиад л гарна. Чимээ чагнан ээжийг харан үүдэндээ зогсоно. Ээжийн ирж явах бараа үл харагдана. Аав чимээгүй...

Ингэж тэр нэгэн намрын яндан хонгиносон өдрүүдийг арай чамай барж

билээ. Магадгүй тэр нэгэн өдөр аавыг огт дуудахгүй болохоор нь сэмээрхэн хатавчаа ярж байгаад аавыг хараагүй бол, намайг харахад аав урьдын адил тэнгэр ширтэн хэвтэж байсан сан бол намрын тэр өдрүүд барагдахгүй байх байсан ч байж мэднэ. Тэгсэн сэн бол ийм явдал болохгүй ч байх байсан байж мэднэ. Даанч тэгсэнгүй.

Намайг хатавчаар харахад аав цаашаа, хана уруу хараад хэвтчихсэн байсан юм. Яагаад ч юм. Тэгэхээр би гэртээ гүйж ороод, “Ааваа” гэж зөөлхөн дуудлаа. Аав огт хариу дуугарсангүй.

Хэчнээн ч татаад би аавыг нааш харуулж хүчирсэнгүй. Тэр цагаас хойш аав “Аан” гээд эргэж хараагүй билээ. Тэр мөчөөс хойш намайг нэг ч удаа дуудаагүй. Тэр цагт аав намайг биш Алтайн их уулсаа л дууддаг байсан юм билээ. Тэгээд дуудсан юм нь биш байсан учраас дуугардаггүй байсан юм билээ. Уг нь би биш Алтайн уулс нь очсон сон бол аавыг аврах байсан ч байж магадгүй гэж би боддог юм. Тийм учраас аавыг хэчнээн ч дуудлаа гэсэн аав ирэхгүй гэдгийг би мэддэг болсон юм. Харин би аавыг хаанаас ч дуудсан очно оо. Олон дуудуулахгүй ээ.

Д.Батбаяр

1. Эхийг дурсамж найруулал гэдгийг жишээгээр батлаарай. \ 4 оноо \

.....
.....

2. “Ингэж тэр нэгэн намрын яндан хонгиносон өдрүүдийг арай чамай барж билээ. гэсэн өгүүлбэрээс холбоо үгийг олж , ингэж гэсэн холбох үгийн утга үүргийг тайлбарлаарай.

.....
.....

3. Эхээс тайлбарлагдаж буй юм, тайлбарлаж буй хэсгийг ялган бичээрэй / 4 оноо /

.....
.....

Зөв бичих дүрэм:

4. Эхээс гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гэж бичих үг 2ыг бичээрэй \2оноо\

.....

5. Дараах үгсийн дүрмийг тайлбарлаарай \2 оноо\
толийг
Урлагийн

Уран зохиол:

6. Эхээс 2 дүрслэх ур маягийг олж, ямар аргаар дүрсэлсэн байгааг тайбарлана уу?

.....
.....

7. Дараах шүлгийн бадгийн утгын тайлбарлан бичээрэй.

Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүхэд
Идэр залуус алс газрыг сонирхон сурахаар одно
Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсахад
Түүний дотроо саран мишээж янагийн үлгэрийг сэмээр өгүүлнэ

.....
.....

8. Дараах зохиол ямар зохиолын хэсэг болохыг тодорхойлж, хам сэдвийг тайлбарлаарай

Хурдлан довтлох уурын тэрэгний өмнөөс намрын салхи хүчтэй үлээхэд хоёр нүдэнд нулимс гялтганан холын барааг харж ядна. Өвгөн жолооч ухасхийх, хийг нэмэхэд дөрвөн хүрд чөлөө завгүй эргэлдэнэ.

.....
.....
.....

ХОЁРДУГААР ХЭСЭГ

1. Эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. / 5 оноо /

Үгийн тоо-25 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно.

2.1 Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

Бөхөн өр мөн а хам нүрөөр бич
Мөншмөг бич нүхирм үрхвэнт мөн
Түнхтншм үрхв мөнн мөншмөг хам нүрөөр
Бөхөн бич өнтр а мөншмөн рөхир н мөн
Мөншмөг өрхөөршмөн . үрхв мөнн
Мөншмөг хам нүрөөр өнтр ..

2.2 Аав мориноос ойчиж, нуруугаа гэмтээн, хэвтэрт оров. Ээж аавын оронд тэмээ малд шогших болсноосоо болоод гэрийн бараа харахыг болив. гэсэн өгүүлбэрийг асуудал дэвшүүлж, мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн 120-140 үгэнд багтаан бичнэ үү?

Монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн анги дэвших
шалгалтын сэдвийг засах чиглэл
А хувилбар

“Монгол толбо” эх

1. Дурсамж найруулал ийм жишээ сонгосон бол оноог гүйцэт өгнө. Жишээг дутуу бичсэн бол хагас оноо өгнө. \ 4 оноо\

Манай ууган охин Москвагийн нэгэн төрөх тасагт мэндлээд хэдхэн хоног болж байсан цаг л даа.

-Охин зүгээр биз! гэж сандран асуувал сувилагч бүсгүй толгой сэгсрэн-Ууцан дээр нь алга дарам газар хөх няц болчхож, Ойччихсон байх аа! Эсвэл чулуугаар цохьчихсон юм шиг хөх няц болсон байна. Би ердөө санахгүй байна гэж хоолойгоо чичрүүлэн хэлэв. Ууцан дээгүүрх “хөх няц” гэдэг нь ердөө л монгол хүүхэд бүрд байдаг төрөлхийн хөх толбо ажээ

2. Холбоо үгийн утга үүрэг \4оноо\

Гэтэл гэдэг холбох үгийг олсон бол хагас оноо өгнө. Утга үүргийг тайлбарласан бол оноо бүрэн өгнө.

3. Тайлбарлагдаж байгаа зүйлээ олж тайлбарлаж бичсэн бол 2 оноо

Тайлбарлаж байгаа хэсгийн жишээ зөв сонгож бичсэн бол 2 оноо

Тайлбарлагдаж байгаа зүйл нь “Хөх толбо” монгол ахуй соёл

Тайлбарлаж байгаа хэсэг нь Хөх толботой төрсөн монгол хүний тухай, Монгол хүний бусдаас онцлог гэдгийг судалсан эрдэмтэдийг дүгнэлт дурдсан бол оноог бүрэн өгнө.

4. Эхээс гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээж бичих үг 2ыг бичээрэй \2оноо\

5. Дараах үгсийгн зөв бичих дүрмийг тайлбарлаарай. \2оноо\

морийг - хамтлагийн - гэсэн 2 үгийн зөв бичих дүрмийг зөв тайлбарласан бол оноо бүрэн өгнө. Дутуу тайлбарласан бол хагас оноо өгнө.

6. Уран зохиол:

Эхээс 2 дүрслэх ур маягийг олж, ямар аргаар дүрсэлсэн байгааг тайбарлана уу/ 5оноо /

2 дүрслэх ур маягаа олсоод болоод тайлбарласан бол оноог бүтэн өгнө. Жишээг олж уран дүрслэл тайлбарлаагүй бол хагас оноо өгнө.

Эсвэл юманд цохьчихсон юм шиг хөх няц болсон байна. Би ердөө санахгүй байна гэж хоолойгоо чичрүүлэн хэлэв.

“Монгол толбо” ийнхүү төрөл арилживч балран арилахгүй явсаар дэлхийн хоёр бөөрөн дээр үлджээ.

7. Дараах зохиол хэн гэдэг зохиолчийн ямар бүтээл болохыг нэрлээд бадгийн утга санааг тайлбарлан бичээрэй.

Д.Нацагдоржийн “Хавар” байгаль дэлхийн өөрчлөлт, өнгө аяс болон хавар цагийн байдлыг дүрслэн бичсэн бол оноо бүтэн өгнө. Зохиолч болон зохиолын нэр бичээгүй бол хагас оноо өгнө.

8. Дараах зохиол ямар зохиолын хэсэг болохыг тодорхойлж, хам сэдвийг тайлбарлаарай

Тэрхүү хийдийн суврагын тэнд гайхамшигтай манжлага цамхагт өлгөсөн хонхны дуу хангинан жингэнэнэ. Бүрээ, бишгүүрийн дуу үргэлжлэн дүнгэнэнэ. Цам, жахар бүжиглэж байгаа юм байжээ. Хөдөөгийн хүмүүс хэд хэдэн зуугаар хуралдаад, эрээн мярааныг өмсөж, ийш тийш зөрөлдөнө

- “Хөдөө талын үзэсгэлэн зохиолын хэсэг бөгөөд энэ хэсгийн хам сэдэв нь “Шашны хам сэдэвтэй.

9. Эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. / 5 оноо /

Үгийн тоо-25, 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно

10. Бичих чадварыг үнэлэх үнэлгээ

№	Үнэглээний шалгуур	Авах оноо	
1	Эхийн бүтэц	-Эхлэл, гол төгсгөл хэсэгтэй бичсэн бол - 2оноо -Аль нэг хэсэг дутуу бичсэн бол 1 оноо	2оноо
2	Найруулга	-Хэрэглээ ба хэлзүйн алдаагүй найруулан бичсэн бол -2 оноо -Өгүүлбэрийн бүтэц оновчтой найруулсан, хэв шинж сайтай - 1оноо -Найруулга утгын алдаатай бол – 0 оноо	2 оноо
3	Үг сонголт	-Дүрслэх ур мачг сайтай,үг олон давтаагүй бол -2 оноо -Үг сонголт оновчгүй, үг олон давтсан бол 1оноо -Сонгосон үг оновчгүй, утгын алдаатай бол 0 оноо	2 оноо
4	Зөв бичих дүрэм	-Зөв бичих дүрмийн алдаагүй, үгийн үндэс зөв бичсэн – 2оноо -Үгийн үндэс буруу бичсэн 2-4 алдсан бол -1 оноо - Зөв бичих дүрмийн алдаатай 5 дээш үг олдсан бол 0 оноо	2 оноо
5	Бичгийн хэв	-бичвэрийг уншихад ойлгомжтой цэгцтэй бичсэн бол -1оноо -Бичгийн соёл сайжруулах шаардлагатай – 0.5 -Ойлгомжгүй бол оноо өгөхгүй	1оноо
6	Үгийн тоо	-Үгийн тоонд багтсан 1оноо -Үгийн тоо дутсан, хэт илүүдсэн бол 0.5 -Юу ч бичээгүй бол оноо өгөхгүй	1оноо

Монгол хэл, бичиг, уран зохиолын анги дэвших шалгалтын
сэдвийг засах чиглэл
Б хувилбар

Алтай эх

1. Эхийг дурсамж найруулал гэдгийг жишээгээр батлаарай. \ 4 оноо \
Жишээ өгүүлбэр: “Ижийгийн чинь аавыг өргөж тээх болоод энэ хээр талд ирж нутаглах болсон юм даа” гэж аавын хэлж байсан бодогдоно. Ийм жишээ олсон бол оноо өгнө.
2. “Ингэж тэр нэгэн намрын яндан хонгиносон өдрүүдийг арай чамай барж билээ. гэсэн өгүүлбэрээс холбоо үгийг олж , ингэж гэсэн холбох үгийн утга үүргийг тайлбарлаарай.
- Арай чамай, Ингэж гэдэг холбоо үг нь өнгөрсөн цаг хугацааг төлөөлж эхний өгүүлбэрийг дараагийн өгүүлбэртэй холбох үүргээр орсон.
3. Эхээс тайлбарлагдаж буй юм, тайлбарлаж буй хэсгийг ялган бичээрэй. / 4 оноо /
Тайлбарлагдаж байгаа зүйлээ олж тайлбарлаж бичсэн бол 2 оноо
Тайлбарлаж байгаа хэсгийн жишээ зөв сонгож бичсэн бол 2 оноо
Монгол хүний нутаг, уул усаа шүтэж амьдардаг тухай өгүүлсэн. Алтай гэдэг нэр өгсний учрыг ойлгож буй хэсгийг сонгосон бичсэн бол оноо бүрэн өгнө.

Зөв бичих дүрэм:

4. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээж бичих үг 2ыг бичээрэй \2оноо\
5. Дараах үгсийн дүрмийг тайлбарлаарай \2оноо\
Толийг, урлагийн гэсэн 2 үгийн зөв бичих дүрмийг зөв тайлбарласан бол оноо бүрэн өгнө. Дутуу тайлбарласан бол хагас оноо өгнө.

Уран зохиол:

6. Эхээс 2 дүрслэх ур маягийг олж, ямар аргаар дүрсэлсэн байгааг тайбарлана уу?
2 дүрслэх ур маягаа олсоод болоод тайлбарласан бол оноог бүтэн өгнө.
Жишээг олж уран дүрслэл тайлбарлаагүй бол хагас оноо өгнө. Жишээ өгүүлбэр:
Ингэж тэр нэгэн намрын яндан хонгиносон өдрүүдийг арай чамай барж билээ.
Жагарын баатрууд шиг баатар эр болох байсан байх байх даа. Тэгсэн бол шөнө орой гадаа гарахдаа огт айдаггүй хүн болох байсан байх ч гэж бас бодогдоно.
7. Дараах шүлгийн бадгийн утгын тайлбарлан бичээрэй.
Сайхан огторгуйн дунд нимгэн цагаан үүл нүүхэд
Идэр залуус алс газрыг сонирхон сурахаар одно
Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсахад
Түүний дотроо саран мишээж янагийн үлгэрийг сэмээр өгүүлнэ
Д.Нацагдоржийн “ Намар” Хүний амьдрал аж ахуй болон намар цагийн өнгө аяс үзэмж өгүүлэн дүрслэн бичсэн бол оноог бүрэн өгнө.
8. Дараах зохиол ямар зохиолын хэсэг болохыг тодорхойлж, хам сэдвийг тайлбарлаарай
Хурдлан довтолох уурын тэрэгний өмнөөс намрын салхи хүчтэй үлээхэд хоёр нүдэнд нулимс гялтганан холын барааг харж ядна. Өвгөн жолооч ухасхийх, хийг нэмэхэд дөрвөн хүрд чөлөө завгүй эргэлдэнэ.
- “Хөдөө талын үзэсгэлэн зохиолын хэсэг бөгөөд энэ хэсгийн хам сэдэв нь “Соёлын хам сэдэвтэй”.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

1. Эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. / 5 оноо /

Үгийн тоо-25, 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно.

Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

1. Бичих чадварыг үнэлэх үнэлгээ

№	Үнэглээний шалгуур	Авах оноо	
1	Эхийн бүтэц	-Эхлэл, гол төгсгөл хэсэгтэй бичсэн бол - 2оноо -Аль нэг хэсэг дутуу бичсэн бол 1 оноо	2оноо
2	Найруулга	-Хэрэглээ ба хэлзүйн алдаагүй найруулан бичсэн бол -2 оноо -Өгүүлбэрийн бүтэц оновчтой найруулсан, хэв шинж сайтай - 1оноо -Найруулга утгын алдаатай бол – 0 оноо	2 оноо
3	Үг сонголт	-Дүрслэх ур мачг сайтай,үг олон давтаагүй бол -2 оноо -Үг сонголт оновчгүй, үг олон давтсан бол 1оноо -Сонгосон үг оновчгүй, утгын алдаатай бол 0 оноо	2 оноо
4	Зөв бичих дүрэм	-Зөв бичих дүрмийн алдаагүй, үгийн үндэс зөв бичсэн – 2оноо -Үгийн үндэс буруу бичсэн 2-4 алдсан бол -1 оноо - Зөв бичих дүрмийн алдаатай 5 дээш үг олдсан бол 0 оноо	2 оноо
5	Бичгийн хэв	-бичвэрийг уншихад ойлгомжтой цэгцтэй бичсэн бол -1оноо -Бичгийн соёл сайжруулах шаардлагатай – 0.5 -Ойлгомжгүй бол оноо өгөхгүй	1оноо
6	Үгийн тоо	-Үгийн тоонд багтсан 1оноо -Үгийн тоо дутсан, хэт илүүдсэн бол 0.5 -Юу ч бичээгүй бол оноо өгөхгүй	1оноо